



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/133

Хэрлэн сум

Хүүхдийн төв байгуулахад дэмжлэг
үзүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ид шидийн орон - Хэнтий" хүүхдийн төв байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичиг:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч

"Харгуй" төрийн өмчит хувьцаат компанийн захирал

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ салбарын харьяа Хэнтий аймаг дахь салбарын дарга

"Хэнтий-Ус" ХХК-ийн захирал

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллага Бор-Өндөр 2 Орон нутгийн хөтөлбөрийн менежер

"Итгэл төгс нөмөр сан" ТББ-ын тэргүүн

2.

2.Хүүхдийн төв байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг ахалж, удирдлага арга зүйгээр хангахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ